



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймаг дахь Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2022/123/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг  
2022 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн

Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт.....	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	15

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХАА	Хөдөө аж ахуй

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: buigan@audit.gov.mn

2022.02.25 № 62

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

**006020079**

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,390,900.00</u></b>	<b><u>4,953,960.00</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,390,900.00	4,953,960.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	763,000.00	996,060.00
35110	Тусгай зориулалттай материал	573,000.00	573,000.00
35130	Эм боох материал	190,000.00	423,060.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	627,900.00	3,957,900.00
35410	Бичиг хэргийн материал	143,400.00	143,400.00
35420	Аж ахуйн материал	484,500.00	3,814,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>44,541,653.16</u></b>	<b><u>37,588,723.24</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	44,541,653.16	37,588,723.24
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	37,291,653.16	30,338,723.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	18,000,000.00	18,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-4,800,000.00	-6,600,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	52,775,150.00	55,275,150.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-32,408,392.98	-39,368,969.82
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,431,324.29	11,431,324.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,706,428.15	-8,398,781.23
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	7,250,000.00	7,250,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,250,000.00	7,250,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b><u>45,932,553.16</u></b>	<b><u>42,542,683.24</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>45,932,553.16</u></b>	<b><u>42,542,683.24</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	45,932,553.16	42,542,683.24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	10,902,720.00	10,902,720.00
51101	Өмч: - төрийн	10,902,720.00	10,902,720.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	35,029,833.16	31,639,963.24
51210	Өмнөх үеийн үр дүн	35,029,833.16	35,029,833.16
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-3,389,869.92
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>45,932,553.16</u></b>	<b><u>42,542,683.24</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>162,797,053.69</b>	<b>179,029,300.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>15,786,153.69</b>	<b>2,576,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	15,786,153.69	2,576,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,786,153.69	2,576,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,220,500.00	2,576,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,565,653.69	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>147,010,900.00</b>	<b>176,453,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	144,810,900.00	168,523,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	144,810,900.00	168,523,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,200,000.00	7,930,000.00

**Булган аймаг дахь Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,200,000.00	4,720,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,210,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>157,929,645.44</b>	<b>182,419,169.92</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>157,929,645.44</b>	<b>182,419,169.92</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	156,827,414.93	177,171,748.64
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	122,124,961.22	134,116,646.10
210101	Үндсэн цалин	69,869,631.84	82,086,161.60
210102	Нэмэгдэл	42,391,425.07	42,217,070.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,863,904.31	9,813,414.02
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	3,370,000.00	3,294,171.42
210205	Эрүүл мэндийн даатгал	3,370,000.00	3,294,171.42
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	6,570,382.27	8,819,095.20
210301	Гэрэл, цахилгаан	502,451.27	624,064.70
210302	Түлш, халаалт	4,866,841.00	4,866,840.50
210303	Цэвэр, бохир ус	1,201,090.00	1,108,190.00
210304	Байрны түрээс	00.00	2,220,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,219,333.00	11,490,450.00
210401	Бичиг хэрэг	1,142,020.00	2,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,188,600.00	3,999,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,193,213.00	1,042,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	680,500.00	4,448,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,488,400.00	2,766,530.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,125,140.00	2,766,530.00
210502	Хоол, хүнс	1,363,260.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	610,400.00	3,660,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	443,800.00	450,000.00
210604	Урсгал засвар	166,600.00	3,210,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,561,100.00	2,422,100.00
210702	Дотоод албан томилолт	3,561,100.00	2,422,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	961,025.00	1,149,826.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	503,200.00	800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,500.00	254,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210807	Газрын төлбөр	10,875.00	10,876.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,921,813.44	9,452,929.92
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,921,813.44	9,452,929.92
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,102,230.51	5,247,421.28
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,102,230.51	5,247,421.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,102,230.51	5,247,421.28
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>4,867,408.25</b>	<b>-3,389,869.92</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>4,867,408.25</b>	<b>-3,389,869.92</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	3,652,720.00	00.00	12,100,082.85	15,752,802.85
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>3,652,720.00</b>	<b>00.00</b>	<b>12,100,082.85</b>	15,752,802.85
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	479,819.00	479,819.00
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>10,902,720.00</b>	<b>00.00</b>	<b>35,029,833.16</b>	45,932,553.16
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>10,902,720.00</b>	<b>00.00</b>	<b>35,029,833.16</b>	45,932,553.16
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>10,902,720.00</b>	<b>00.00</b>	<b>35,029,833.16</b>	45,932,553.16
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-3,389,869.92	-3,389,869.92
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>10,902,720.00</b>	<b>00.00</b>	<b>31,639,963.24</b>	42,542,683.24

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>152,231,400.00</b>	<b>179,029,300.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,220,500.00</b>	<b>2,576,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,220,500.00	2,576,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,220,500.00	2,576,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,220,500.00	2,576,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>147,010,900.00</b>	<b>176,453,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	144,810,900.00	168,523,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	144,810,900.00	168,523,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,200,000.00	7,930,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,200,000.00	4,720,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,210,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>150,031,400.00</b>	<b>176,529,300.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>150,031,400.00</b>	<b>176,529,300.00</b>

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>148,929,169.49</b>	<b>171,281,878.72</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	122,109,049.22	134,116,646.10
210101	Үндсэн цалин	69,853,719.84	82,086,161.60
210102	Нэмэгдэл	42,391,425.07	42,217,070.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,863,904.31	9,813,414.02
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	3,370,000.00	3,294,171.42
210205	Эрүүл мэндийн даатгал	3,370,000.00	3,294,171.42
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	6,570,382.27	8,819,095.20
210301	Гэрэл, цахилгаан	502,451.27	624,064.70
210302	Түлш, халаалт	4,866,841.00	4,866,840.50
210303	Цэвэр, бохир ус	1,201,090.00	1,108,190.00
210304	Байрны түрээс	00.00	2,220,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,219,333.00	14,820,450.00
210401	Бичиг хэрэг	1,142,020.00	1,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,188,600.00	4,999,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,193,213.00	1,042,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	680,500.00	7,778,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,527,880.00	2,999,590.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,164,620.00	2,999,590.00
210502	Хоол, хүнс	1,363,260.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	610,400.00	3,660,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	443,800.00	450,000.00
210604	Урсгал засвар	166,600.00	3,210,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,561,100.00	2,422,100.00
210702	Дотоод албан томилолт	3,561,100.00	2,422,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	961,025.00	1,149,826.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	503,200.00	800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,500.00	254,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210807	Газрын төлбөр	10,875.00	10,876.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,102,230.51</b>	<b>5,247,421.28</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,102,230.51	5,247,421.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,102,230.51	5,247,421.28
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>2,200,000.00</b>	<b>2,500,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>2,200,000.00</b>	<b>2,500,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,200,000.00</b>	<b>2,500,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	2,200,000.00	2,500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,200,000.00	2,500,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-2,200,000.00</b>	<b>-2,500,000.00</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	170,923,700.00	165,851,878.72
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	170,923,700.00	165,851,878.72
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	170,923,700.00	165,851,878.72
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	137,483,000.00	134,116,646.10
210101	Үндсэн цалин	80,865,900.00	82,086,161.60
210102	Нэмэгдэл	43,897,100.00	42,217,070.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,720,000.00	9,813,414.02
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	3,373,300.00	3,294,171.42
210205	Эрүүл мэндийн даатгал	3,373,300.00	3,294,171.42
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7,595,000.00	6,599,095.20
210301	Гэрэл, цахилгаан	695,000.00	624,064.70
210302	Түлш, халаалт	5,630,000.00	4,866,840.50
210303	Цэвэр, бохир ус	1,270,000.00	1,108,190.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,860,000.00	14,820,450.00
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	1,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	4,999,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,051,600.00	1,042,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	30,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,778,400.00	7,778,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,000,000.00	2,999,590.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,000,000.00	2,999,590.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	450,000.00	450,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	450,000.00	450,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,000,400.00	2,422,100.00
210702	Дотоод албан томилолт	3,000,400.00	2,422,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,162,000.00	1,149,826.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	800,000.00	800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	55,000.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	266,000.00	254,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210807	Газрын төлбөр	11,000.00	10,876.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	170,123,300.00	171,099,300.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	167,723,300.00	168,523,300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	167,723,300.00	168,523,300.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	2,400,000.00	2,576,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,400,000.00	2,576,000.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	1,020.00	58,301.00
620001	Удирдах ажилтан	555.00	7,878.00
620002	Гүйцэтгэх ажилтан	455.00	4,545.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	45,878.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>7,930,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>7,930,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	7,930,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	2,220,000.00
210304	Байрны түрээс	2,220,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,710,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00
210604	Урсгал засвар	3,210,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	7930000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	7,930,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,720,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,210,000.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймаг дахь Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймаг дахь Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монгол Улсын Шүүхийн Шинжилгээний тухай хуулийн 37.1-д "Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн" гэж заасны дагуу биет баримтыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, шинжлэх үе шат бүрт онцгой анхаарч, үзлэг, шинжилгээг тал бүрээс

нь, шинжлэх ухааны үндэслэлтэй, хуулийн дагуу явуулж, нотлох баримтын эх сурвалжийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, улсын хэмжээнд шинжлэн магадлахуйн цогц үйл ажиллагааг бий болгох эрхэм зорилготойгоор үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Өөрөөр хэлбэл шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд /хэрэг бүртгэгч, мөрдөгч, прокурор, шүүгч/-ийн тогтоол захирамжаар тэднээс шинжээч, шинжээч эмч нар хараат бус байж, гагцхүү хуульд захирагдан үйл ажиллагаагаа бие даан явуулдаг.

Албаны үйлчилгээний нэр, төрөл гэвэл:

1. Криминалистикийн шинжилгээний чиглэлээр
  - Мөр судлалын шинжилгээ
  - Гарын мөрний шинжилгээ
  - Галт зэвсгийн шинжилгээ
  - Бичиг баримтын шинжилгээ
  - Хүний дүр төрхийн шинжилгээ
2. Шүүх эмнэлгийн шинжилгээний чиглэлээр
  - Амьд хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг шинжилгээ
  - Нас барагчийн цогцост хийх шинжилгээ
  - Хүний нас тогтоох, эцэг тогтоох, бэлгийн гэмт хэргийн үзлэг шинжилгээ
3. Хими, биологийн шинжилгээний чиглэлээр
  - Согтолтын зэрэг тогтоох
  - Хордлогын шинж тогтоох /угаарын хий бусад хордлогын/
  - Цусны бүлэг тогтоох
4. Сан бүрдүүлэх чиглэлээр
  - Гарын хээний “Папилон” системийн сан
  - Галт зэвсгийн “Арсеналь” системийн сан
  - Гутлын улны мөрний сан
  - Тээврийн хэрэгслийн дугуйны мөр, тэнхлэг хоорондын зайн сан гэх мэт .

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод чанарын баталгаажуулалт, статистик хариуцсан ахлах ажилтан ажилладаг хэдий ч тухайн ажилтан чиг үүргээ хэрэгжүүлснээр тодорхой үр дүн гарсан эсэх нь тодорхойгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймаг дахь Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 170,923.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,709.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,196.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган аймаг дахь Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,389.9 мянган төгрөгөөр буюу 7.38 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс буурсан үндсэн хөрөнгийн элэгдэл тооцож хассан дүн нөлөөлсөн байна. Бараа материалын дүн өссөн нь зарцуулалт худалдан авалтаас бага байгаатай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	1,390.9	4,953.9	3,563.0
Үндсэн хөрөнгө	44,541.6	37,588.7	(6,952.9)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>45,932.5</b>	<b>42,542.6</b>	<b>(3,389.9)</b>
Өр төлбөр	0.0	0.0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	45,932.5	42,542.6	(3,389.9)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>45,932.5</b>	<b>42,542.6</b>	<b>(3,389.9)</b>

Бараа материалын данс 4,953.9 мянган төгрөг болж 3,563.0 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал, түлш тослох материал, аж ахуйг материал худалдан авснаас шалтгаалсан байна. Тайлангийн хугацаанд төсвийн хөрөнгөөр 20,651.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 17,088.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна. Тайлант онд шилжсэн, шилжүүлэн авсан өөрчлөлтгүй, акталж устгасан бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 37,588.7 мянган төгрөг болж 6,952.9 мянган төгрөгөөр буурсан нь тухайн жилийн элэгдлээс хамаарсан байна. Харин тайлант хугацаанд нэмэлт дансаар орж ирсэн 2,500.0 мянган төгрөгөөр зөврийн компьютер худалдаж авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 42,542.6 мянган төгрөг болж 3,389.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Булган аймаг дахь Шүүхийн шинжилгээний албаны санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 16,232.2 мянган төгрөгөөр буюу 9.97 хувиар, нийт зардал өмнөх оноос 24,489.5 мянган төгрөгөөр буюу 15.5 хувиар тус тус өссөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Булган аймаг дахь Шүүхийн шинжилгээний алба нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 227,627.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 227,627.3 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 59,104.0 мянган төгрөгөөр бууруулан 168,523.3 мянган төгрөгөөр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 168,523.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, нэмэлт санхүүжилтийн орлого 7,930.0 мянган төгрөг, 2,576.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогоос, урсгал үйл ажиллагаанд 176,529.3 мянган төгрөгийг зарцуулж, 5,247.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 176,529.3 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлаас 3,366.3 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын зардлаас 79.1 мянган төгрөг, томилолтын зардлаас 578.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 995.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлаас 39.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрөөс 12,1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн санхүүжилтээс 4,720.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан. Үүнээс 2,220.0 орон сууцны түрээсийн зардалд, 2,500.0 мянган төгрөг зөөврийн компьютер худалдан авч зарцуулсан байна.

Сангийн яамны 2021 оны 12-р сарын 05-ны өдрийн тушаалаар давсан орлого бүхий 3,210.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар санхүүжилт олгосон ба нийт дүнгээр автомашины засварын зардалд зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Ажилтны хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж бодоходоо цалингийн дундаж болон бодох хоногоо илүү тооцож 107.9 мянган төгрөгийг илүү бодож олгосон байна. Энэ нь Албан хаагчдын хөдөлмөрийн чадвар тор алдалтын тэтгэмжийг "Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай" хуулийн 17-р зүйлийн дагуу бодож, олгож байх.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Булган аймаг дахь Шүүхийн шинжилгээний алба 168,523.3 мянган төгрөгийн 149 мэдээллийг ил тод байршуулахаас хуулийн хугацаанд 140,154.0 мянган төгрөгийн 127 мэдээллийг мэдээлж, 28,369.3 мянган төгрөгийн 22 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мөн шилэн дансанд мэдээлэх мэдээллийн талаар талбар бүрээр зөвлөгөө өгсөн.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Бараа материалын орлого зарлагын баримт болон шаардах хуудас тамга, тэмдгээр баталгаажаагүй, зарим анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, 51.6 мянган төгрөгийн 6 баримтгүй гүйлгээ хийгдсэн байна Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасны хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон алдаа зөрчил илрээгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар нэмэлт санхүүжилтийн дансаар, орсон санхүүжилтээр гарсан зардал тухай бүрт нь тайлагнаагүй бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс дансанд тайлагнаж байна. Цаашид зардлыг Сангийн сайдын 2021 оны 190 тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” журмын дагуу бүртгэж тайлагнахад анхаарах шаардлагатай.

#### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 159.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 159.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

##### **4.1 Залруулсан алдаа**

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй.

##### **4.2 Акт**

Аудитын явцад акт байхгүй.

##### **4.3 Албан шаардлага**

Тайлант онд албан шаардлага байхгүй байна.

##### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Зардлын данстай холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

Ажилтны хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж бодохдоо цалингийн дундаж болон бодох хоногоо илүү тооцож 107.9 мянган төгрөгийг илүү бодож олгосон байна. Энэ нь албан хаагчдын хөдөлмөрийн чадвар тор алдалтын тэтгэмжийг "Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай" хуулийн 17-р зүйлийн заалттай нийцэхгүй байна.

##### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Холбогдох хууль, журмыг баримтлан ажиллах

#### **2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

##### **2.1. Илрүүлэлт:**

Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу 51.6 мянган төгрөгийн ө баримтгүй гүйлгээ хийгдсэн байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заалттай нийцэхгүй байна.

##### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Анхан шатны баримтыг хууль, дүрмийн дагуу иж бүрэн баримтаар гүйлгээг хийж хэвших.

#### **3. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

##### **3.1. Илрүүлэлт:**

Шилэн дансанд 5.7 саруудад 22 удаагийн мэдээлэл хугацаа хоцроож, Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн мэдээллийг оруулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

##### **3.2. Өгсөн зөвлөмж:**

Байгууллагын шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлж, дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, хариуцлагыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/


д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шүүхийн шинжилгээний алба	3	159.5	-	-	-	-	-	-	3	159.5
Дүн		3	159.5	-	-	-	-	-	-	3	159.5

### АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

"БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ" ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН


АУДИТОР:



Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ :



Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:



Ж.ЭНХЦООДОЛ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАНАЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Д.АНХБАЯР